



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

209 /209/ 2021.12.27

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

1968 он.

БХЯ-ны сайдын тушаалаар Армийн төмөр замын барилга засвар, сэргээн босголтын тусгай баталын болгон өөрчлөхөөр шийдвэрлэснээр иргэний хамгаалалтын цэрэг үүсэв.

“ТУСГААР ТОГТНОЛ-2021” ПРАКТИК БУУДЛАГЫН ТЭМЦЭЭНИЙГ МПБХ ӨНГӨЛЛӨӨ



Монгол Улсад Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалахын сайдын нэрэмжит “Тусгаар тогтнол-2021” практик буудлагын улсын аварга шалгаруулах тэмцээн өнгөрсөн долоо хоногт Монголын практик буудлагын холбооны төв клубийн буудлагын талбайд амжилттай зохион байгуулагдаж шилдгүүдээ тодрууллаа.

Тэмцээнийг БХЯ, ЗХЖШ, “Монголын практик буудлагын холбоо”-ны томилгоот алба хаагчид зохион байгуулсан бөгөөд БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ДЦШ, ОБЕГ, ЦЕГ, ТТХГ, ШШГЕГ, АТГ, ШШҮХ, ҮБХИС-иас гадна “Монголын практик буудлагын холбоо”-ны 145 тамирчин цэц мэргэнээ сорин өрсөлдөв.

Гар бууны опен ангилалд нийт 11 тамирчин өрсөлдсөнөөс хувийн дүнгээр эхний байруудад ТТХГ-ын тамирчин Х.Моломжамц, ЦЕГ-ын тамирчин О.Энхжин, ТТХЕГ-ын тамирчин О.Пүрэвням нар шалгарсан бол гар бууны стандарт ангилалд нийт 39 тамирчнаас БХЯ, ЗХЖШ-ын тамирчин П.Оюунбат, Монголын хамгаалалтын буудлагын холбооны тамирчин Э.Оюут,

Б.Батбаяр нар шалгарав.

Гар бууны стандарт ангилалд 9 баг өрсөлдсөнөөс багийн дүнгээр МХБХ-ын “Down zero”, ЦЕГ-ын “Ирвэс баг”, Зэвсэгт хүчний нэгдүгээр баг эхний байруудад шалгарлаа.

Гар бууны сумтай карабины төрөлд нийт 30 тамирчин өрсөлдсөнөөс хувийн дүнгээр ТТХГ-ын Б.Хүслэн, ШШГЕГ-ын тамирчин Б.Тэмүүлэн, МПБХ-ны тамирчин Х.Тэмүүжин нар хошуучиллаа. Гар бууны сумтай карабины төрөлд 7 эмэгтэй тамирчин өрсөлдсөнөөс тэргүүн байрт МПБХ-ны тамирчин Б.Энхжаргал, хоёрдугаар байрт МПБХ-ны тамирчин Г.Эгшиглэн, гуравдугаар байрт ШШГЕГ-ын тамирчин Э.Эна нар бусдыгаа манлайлав.

Гар бууны сумтай карабины төрөлд 8 баг өрсөлдсөнөөс багийн дүнгээр тэргүүн байрт МПБХ-ны “Family” баг, хоёрдугаар байрт МПБХ-ны “DVC” баг, гуравдугаар байрт ШШГЕГ-ын “Force” баг шалгарсан бол карабины опен ангилалд нийт 25 баг тамирчин өрсөлдсөнөөс хувийн дүнгээр тэргүүн байрт ХХЕГ-ын Б.Соронзонболд, хоёрдугаар байрт МПБХ-ны тамирчин Э.Эрдэнэхаалиун, гуравдугаар байрт МПБХ-ны тамирчин

Б.Алтанбагана нар шалгарав.

Түүнчлэн карабины опен ангилалд 6 баг өрсөлдсөнөөс багийн дүнгээр тэргүүн байрт МПБХ-ны “DLC” баг, хоёрдугаар байрт МПБХ-ны “Triple Alpha” баг, гуравдугаар байрт ХХЕГ-ын “BPSF” баг тус тус шалгарсан юм.

Харин карабины стандарт ангилалд 40 тамирчин өрсөлдсөнөөс хувийн дүнгээр тэргүүн байрт ЦЕГ-ын тамирчин Н.Батмөнх, хоёрдугаар байрт ТТХГ-ын тамирчин Ц.Адилтулга, гуравдугаар байрт ЦЕГ-ын тамирчин О.Баттөгс нар эхний байруудад тунав.

Шинэ төрөл болох карабины стандарт ангилалд өсвөрийн 5 тамирчин өрсөлдсөнөөс хувийн дүнгээр МПБХ-ны тамирчин Н.Амир, А.Цовоо, Б.Аминаа нар тэргүүлсэн бол Карабины стандарт ангилалд 10 баг өрсөлдсөнөөс багийн дүнгээр тэргүүн байрт ЦЕГ-ын “Ирвэс”, хоёрдугаар байрт ТТХГ-ын “Черби”, гуравдугаар байрт ХХЕГ-ын “BPSF” багууд бусдыгаа хошуучиллаа.

Ийнхүү тус тэмцээний шилжин явах цомын төлөө 2 өдөр өрсөлдсөн 12 байгууллагын 145 тамирчин 11 багц медалийн төлөө авхаалж самбаа, цэц мэргэнээ сорьж нийлбэр дүнгээр МПБХ-

ны баг тамирчид 4 алт, 5 мөнгө, 3 хүрэл медаль цуглуулсан амжилтаар тэргүүлж шилжин явах цомын эздээр тодорсон бол 2 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль цуглуулсан амжилтаар ЦЕГ болон ТТХГ-ууд аман хүзүүдлээ.

Шилдгүүдийн шагналыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг болон төрлийн цэргийн байгууллагын удирдлагууд гардуулан өгсөн юм.

Монголын практик буудлагын холбооны төв клубийн буудлагын талбайд зохион байгуулагдсан тус тэмцээн нь төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын хурд чух, авхаалж самбаа, цэц мэргэнийг сорихоос гадна тэдний ур чадварыг дээшлүүлэх, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, практик буудлагаар хичээллэгч тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх, буудлагын тамирчдын залуу халааг бэлтгэж цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн ач холбогдол өндөртэй тэмцээн болж өнгөрлөө.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН
2.264.962 /69.6%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН
2,161.328 /66.4%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
862.179 26,5%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
7064 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
300

ЭДГЭРСЭН
6636

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 280,332,696

Эдгэрсэн
Нийт: 250,360,687.

Нас барсан
Нийт: 5,416,370

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:
Эд эдлэл, идээ ундаа олдоно
Наран ургах, шингэх:
08.41-17.05
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Төрөн түгэхүй
Суудал:
Шороо

Энэ өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба гарагийг тахиж, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

ДОРНЫН ЗУРХАЙ:

Энэ өдөр үхэр, могой жилтнээ эерэг сайн

цахим шууданд

"ТЭРГҮҮНИЙ АРДЫН АВЬЯАСТАН ХАМТ ОЛОН" ШАЛГАРУУЛАВ



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

тэргүүн байрт хошууч А.Ганболд захирагчтай Мотобуудлагын батальон удирдлагын тасаг, холбооны алба удаах байруудыг эзэлж шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

гоцлол дуучнаар дэслэгч Б.Сайнтогтох, шилдэг уран уншигчаар Х.Чанцал, шилдэг бүжгийн төрлөөр Мотобуудлагын батальоны бүжгийн хамтлаг, шилдэг язгуур урлагийн төрөлд ахмад Н.Гантулга нар шалгарлаа.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

Нэгтгэлийн 2021-2022 оны сургуулийн жилийн "Тэргүүний ардын авьяастан хамт олон" шалгаруулах уралдааныг урлагийн 6 төрлөөр зохион байгуулж явууллаа.

Уралдааны

Уралдааны шилдэг

АРДЫН АВЬЯАСТНУУДАА ШАЛГАРУУЛАА



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Ангийн 2021 оны сургуулийн жилийн сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр "Тэргүүний ардын авьяастан" шалгаруулах урлагийн үзлэгийг амжилттай зохион байгуулж явууллаа.

Тус наадмыг Налайх соёлын ордны уртын дууны багш МУСТА Б.Хүрэлбаатар, Налайх соёлын ордны

дэргэдэх "Эрхэс" хамтлагийн ахлагч МУСТА Г.Батцэнгэл, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа Л.Чинзориг нар шүүн явуулсан бөгөөд тус тэмцээнд 8 тасаг, алба, салбарууд урлагийн 6 төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ тордуулсан юм.

Тэргүүн байрт штаб, дэд байрт ар талын алба, удаах байрт замын ротын хамт олон шалгарсан бол

"Шилдэг гоцлол дуучин"-аар инженер сапёрын ротын ахлагч Г.Тулга, "Шилдэг язгуур урлаг"-ийн төрөлд замын ротын "Исэргэнэ" бүжгийн хамтлаг, "Шилдэг уран уншигч" төрөлд Үлээвэр найрал хөгжмийн хөгжимчин ахлах ахлагч М.Азжаргал, "Шилдэг гоцлол бүжиг"-ийн төрөлд холбооны сувгийн техникч, телефончин ахлагч У.Гоёцэцэг нар тус тус шалгарлаа.

Дэслэгч Р.БИЛЭГ



АНГИЙН АВЬЯАСЛАГ ЦЭРГҮҮДИЙГ ТОДРУУЛЛАА



Зэвсэгт хүчний 167 дугаар анги Ангийн цэргийн чөлөөт цагийг өнгөрүүлэх ажлын хүрээнд

алба хаагчдын дунд "Хөрөг болон нөхөрсөг шог зураг"-ийн уралдааныг МББ-ы салаа, салбаруудын хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион явуулав. Үүнд нийт 29 бүтээл

ирснээс тэргүүн байрт АХБ-ны байлдагч Ш.Ган-Өлзий, дэд байрт танкийн ротын байлдагч Э.Тэнгис, гутгаар байрт АХБ-ны байлдагч Э.Өсөхбаяр нарын бүтээл шагналт байрт шалгарлаа.

Мөн МББ болон тусгай салбаруудын хугацаат цэргийн алба хаагчдын дунд тэргүүний урлагийн авьяастан шалгаруулах тэмцээнийг удирдамжийн дагуу зохион явууллаа. Үүнд шилдэг авьяаслаг салаа, шилдэг гоцлол дуучин, уран уншигч, шилдэг гоцлол хөгжимчин, авьяастан байлдагч гэсэн нийт 5 номинациар шилдгүүддээ тус тус шалгарууллаа.

Дэслэгч Б.БАТЗАЯА

СОНСОГЧ АХ, ЭГЧ НАРТАА БАЯРЛАЛАА



ҮБХИС-ийн Сонсогчийн батальоны 2 дугаар ротын сонсогч, офицер, ахлагч нар саанчлан шинэ оны баярыг угтаж гэр хорооллоор явж зарим хүүхэд багачуудад өөрсдийнхөө нөөц боломжоор шинэ жилийн баярын бэлэг гардууллаа.

Энэ үеэр зарим сонсогчид "Энэ хүүхдүүд дундаас л ирээдүйн генералууд, улс төр, урлаг, спортын алдартнууд төрж гарна. Эх орны минь ирээдүй болсон хүүхэд багачууд үргэлж инээж байх болтугай" гэв. Үүний хариуд бэлэг гардан авсан хүүхдүүд чин сэтгэлээсээ "Сонсогч ах эгч нартаа баярлалаа" хэмээн дуу нэгтэй хэлж байлаа.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Монгол цэргийн нэгдсэн холбооноос Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Дотоод хэргийн их сургуультай хамтран "Хүчирхийллээс ангид нийгэм байгуулахад монгол эрчүүдийн үүрэг оролцоо" сэдэвт хэлэлцүүлгийг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ахлах ахлагч М.Азжаргал, "Шилдэг гоцлол бүжиг"-ийн төрөлд холбооны сувгийн техникч, телефончин ахлагч У.Гоёцэцэг нар тус тус шалгарлаа.

Энэхүү хэлэлцүүлэгт Монгол цэргийн нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Тогоо, Удирдах зөвлөлийн гишүүн, Монгол Улсын гавьяат багш, доктор профессор Б.Галиндэв, Соёлын гавьяат зүтгэлтэн, доктор



Ж.Цогтсугар, Ажлын албаны зөвлөх Д.Ганбаатар, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Эрүүл мэндийн яамны Нийтийн ЭМГ-ын Халдварт бус өвчний хэлтсийн дарга Г.Ганхуяг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Б.Алтантулга, Зэвсэгт хүчний Жанжин штабын хэлтсийн дарга, хурандаа Х.Баньд, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны шинжилгээ, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн цагдаагийн дэд хурандаа Д.Энхсайхан, Жендэрийн үндэсний



хорооны эрэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Батхишиг нар оролцож илтгэл тавилаа.

Энэхүү хэлэлцүүлэг нь Монгол эрчүүдийн улс орныхоо батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам, хууль ёсыг сахиулах, эдийн засаг, зах зээлийн бүтээн байгуулалтын үйл хэрэгт гар бие оролцох, хойч үеэ зөв төлөвшүүлэх, хүчирхийллээс ангид нийгэм байгуулах үйл хэрэгт эрчүүдийн тэр дундаа мөртөстэй эрчүүдийн манлайлыг бий болгох, үүрэг оролцоог нь нэмэгдүүлэх, хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг бууруулахад чиглэсэн чухал үр дүнтэй арга хэмжээ боллоо.

